

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023.04.27

Улаанбаатар хот

Тус компанийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит Хурлыг, хурал хийхээр товлосон зарын дагуу 2023.04.27 ны өдрийн 14 цагт Компанийн хурлын танхимаас цахим хэлбэрээр шууд дамжуулав.

Хурлын дэгийн дагуу хурал эхлэхээс өмнө Тооллогын Комисс Хувьцаа Эзэмшигчдийн Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэж, саналын эрхийн тоо, хурлын ирц, Тооллогын Комиссын 2022.04.27 ны өдрийн “Хүчин төгөлдөрт тооцох тухай” №01 тоот тогтоолыг тооллогын комиссын дарга Б.Тэргэл уншиж танилцуулав. / Уг тогтоолыг хурлын материалынр хуудсанд хавсаргав./

Тооллогын Комиссын дарга Б.Тэргэл : Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хуралд 1.023.703 ширхэг хувьцаа эзэмшсэн 3.971 хувьцаа Эзэмшигчдээс саналын эрх бүхий 884.613 ширхэг хувьцаа эзэмшсэн 149 хувьцаа эзэмшигч бүртгэгдсэн байна. Энэ нь нийт хувьцааны 86,41 % -ыг төлөөлж байна. Иймээс Компанийн тухай хуулийн 69-р зүйлийн 1-д заасан заалтыг үндэслэн “Хурал хүчин төгөлдөрт тооцсугай” гэв.

Үүний дараа Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор томилогдсон хурал дарга тус компаний санхүү хаариуцсан дэд захирал, аж үйлдвэрийн гавьяат ажилтан Б.Бурмаа нээж хурлын дэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор томилогдсон хурлын тэргүүлэгчид, нарийн бичгийн дарга болон тооллогын комиссыг танилцуулж ажилдаа орохыг урив.

Хурал даргалагч Өнөөдрийн хурлаар:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцэн батлах
 2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
 3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны төсвийг батлах
 4. Ногдол ашгийг нэгж хувьцаанд 350 төгрөгөөр хуваарилах асуудлуудыг хэлэлцэнэ гэсний дагуу хурлын дараалал ёсоор :
-
1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан болон компанийн 2023 оны төлөвлөгөөг Гүйцэтгэх захирал М.Базар-Ууган илтгэв.
 2. Компанийн 2022 оны санхүүгийн тайлан болон Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг компанийн нягтлан бодогч Эрдэнэцэцэг тайлагнав.
 3. “Ногдол ашиг хуваарилах” тухай ТУЗ-ийн тогтоол болон 2023 оны төсвийг уншиж танилцуулав.

Хөтлөгч: Компанийн вэйп сайтад болон цахим хуудсаар олон асуулт ирлээ. Эдгээр асуултуудыг багцалж хариулъя.

- Талх Чихэр ХК-ийн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал хэрхэн хангагдаж ажиллаж байна вэ?
- Бүтээгдэхүүн хөгжүүлэлт ямар түвшинд хөгжиж, хэрэглэгчдэд шинэ нэр төрлийн бүтээгдэхүүний сонголтыг бий болгосон уу?
- Хэрэглэгч, харилцагчийн санал хүсэлтийг бүтээгдэхүүн хөгжүүлэлтэндээ хэрхэн тусгаж авч үздэг вэ? гэсэн асуултанд ерөнхий технологич Д.Одонгэрэл хариулна.

Хариулт : Бүх насны хүмүүсийн хэрэглээнд өдөр дутам хэрэглэгчдэд хүрдэг талх, гурилан бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангаж ажиллах нь бидний үйл ажиллагааны гол зорилго байдаг. Иймээс бүтээгдэхүүн үйлдвэрлэх орчин нөхцөл, ашиглаж буй түүхий эд материалын аюулгүйн үзүүлэлтүүд, сав баглааны шинж чанар тухайн бүтээгдэхүүнийг боловсруулж буй технологийн арга аргачлал, мөн бэлэн бүтээгдэхүүний хими микробиологийн шинжилгээний дүгнэлт зэрэгт ихээхэн ач холбогдол өгч ажиллаж байна. Энэхүү нэгдмэл байдлыг хангахын тулд тус компани нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт шаардлагыг мөрдөж ажиллахаас гадна байгууллагын үйл ажиллагааг илүү тогтвортой сайжруулах Чанарын менежментийн тогтолцооны ISO-9001, эрүүл аюулгүй хүнс үйлдвэрлэхэд чиглэсэн Хөдөлмөр аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO-22000, ажилтнуудын хөдөлмөр эрхлэхтэй холбоотой эрүүл мэндийн хохирлоос урьдчилан сэргийлэх ач холбогдол бүхий Хөдөлмөр эрүүл мэндийн аюулгүй байдал ISO 45001 зэрэг олон улсын стандартын шаардлагыг хангаж үйл ажиллагаандаа байнгын сайжруулалт хийж ажилласаар байна. Хэрэглэгчийн санал хүсэлтийг утас, имэйл, сошиал сувгуудаар тогтмол хүлээн авч бүтээгдэхүүн үйлчилгээндээ тэдний санал бодлыг тусгах, сонголтод нь нийцүүлэн сайжруулах зэрэг ажлуудыг хийж хэрэгжүүлж ирсэн. Жишээлбэл бид харилцагч хамтрагч байгууллагуудын санал хүсэлт шаардлагын дагуу B2B үйлчилгээг үйлчилгээг үзүүлж МИАТ ХК-ийн олон улсын нислэгийн катерингийн үйлчилгээнд мөн Оюу толгой уул уурхайн компанийн ханган гийлүүлэгчээр сонгогдсон, төдийгүй олон улсын франчайз хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт чанар стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг тасралтгүй ханган нийлүүлэх үүрэг хүлээн ажиллаж байна.

Хөтлөгч: Шинэ залуу ажилчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах талаар ямар арга хэмжээ авдаг вэ? гэсэн асуултанд Аж үйлдвэрийн гавьяат ажилтан хурлын дарга Бурмаа хариулнаа.

Хариулт: Энэ асуултанд манай компанийн хүний нөөцийн албаны дарга хариулах байсан боловч гадаад улсад албан томилолтоор ажиллаж байгаа тул би хариуъя. Манай компани шинэ залуу ажилчдыг тогтвор суурьшилтай ажиллуулахын тулд хүний нөөцийн хөтөлбөр хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд олон талт арга хэмжээнүүдийг зохион байгуулдаг талаар манай гүйцэтгэх захирал тайландаа тодорхой ярьсан, би давтахгүйгээр товч мэдээлэл өгье, манай ажилчид үндсэн цалингаас гадна гүйцэтгэлийн, удаан жил тогтвор суурьшилтай ажилласны, ур чадвар, зэрэг дэв, түлхүүр ажилтаны нэмэгдэл, дотоод журамд заасан хөнгөлөлтүүдийг эдэлдэг болно.

Үүний дараа тооллогын комиссын дарга Б.Тэргэл "Саналын хуудсыг тоолж, дүнг танилцуулах" тухай тогтоолыг уншиж танилцуулав.

Компанийн нийт 1.023.703 ширхэг хувьцаа эзэмшиж буй 3.971 хувьцаа эзэмшигчдээс хуралд 884.613 ширхэг хувьцаа эзэмшсэн 149 эзэмшигч оролцов. Тооллогын комисст ирсэн саналын хуудас 149 ширхэг, үүнээс асуулга тус бүрээр хүчинтэй саналын тоо 145 ширхэг, асуулга тус бүрээр хүчингүй саналын хуудасны тоо 4 байна.

1. Компаний 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлахыг зөвшөөрсөн 884.489 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо байхгүй.
2. Компанийн 2022 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлахыг зөвшөөрсөн 690,603 ширхэг хувьцаа буюу нийт саналын 78,08 хувь татгалзсан санал байхгүй, түдгэлзсэн 193.886 ширхэг хувьцаа буюу нийт саналын 21,92 хувь
3. Компанийн ТУЗ-ийн 2023 оны зардлын төсвийг 66.840.000 төгрөгөөр батлахыг зөвшөөрсөн 690.603 ширхэг хувьцаа буюу нийт саналын 78,08 хувь, татгалзсан саналын тоо байхгүй, түдгэлзсэн 193.886 ширхэг хувьцаа буюу нийт саналын 21,92 хувь
4. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 350 төгрөгөөр хувиарлахыг зөвшөөрсөн 884,067 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,95 хувь, татгалзсан санал 422 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,05 хувь түдгэлзсэн санал байхгүй байна гэж уншиж танилцууллаа.

Тооллогын Комиссын дүнг үндэслэн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлаас №01 тоот тогтоол гаргаж хурлын дарга Б.Бурмаа уншиж сонсгов.

Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаас ТОГТООХ НЬ :

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн өгсөн дүгнэлтийг зүйтэй гэж үзсүгэй.
2. Компанийн 2023 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсугай. Үүнд :
 - 2010 онд ашиглалтанд орсон Юнимакс, Юнилайн нарийн боовны шугамын үйл ажиллагааг зогсоон, акталж данснаас хасах нь зүйтэй гэж үзсүгэй.
 - Цаашид харийн боовны зах зээлийг хадгалж үлдэхийн тулд хөрөнгө оруулалт хийх, менежментийн үйл ажиллагааг авч явах чадамжтай компанитай гэрээгээр ажиллахыг зөвшөөрсүгэй.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны төсвийг 66.840.000 төгрөгөөр баталсугай.
4. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 350 төгрөгөөр тогтоосугай гэж тогтоолыг уншиж танилцуулсанаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ажиллагаа өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА

Б.БУРМАА

ТЭМДЭГЛЭСЭН

И.ӨЛЗИЙБАЯР

902110011833074